

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.03.11-03.15

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсын томоохон хэсгийг бүрдүүлдэг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр өссөн бол аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна. "Apple" болон "Nvidia" компаниудын хувьцааны ханш өсөж, харин "Boeing" компанийн 737 Max 8 загварын нисэх онгоц хоёр дахь удаагаа осолдсоноор тус компанийн хувьцааны ханш унажээ.

Энэ долоо хоногийн эхээр АНУ, БНХАУ удахгүй худалдааны хэлцэл байгуулна гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд ихээр үүсч, хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэв. Харин "Bloomberg" агентлаг тус улсын тэргүүнүүд энэ оны 4-р сар хүртэл ямар нэгэн уулзалт хийхгүй талаар мэдээлж зах зээлийн индексүүд бага зэрэг буурчээ.

1-р сард АНУ-ын шинэ орон сууцны худалдаа 7 орчим хувиар багассан ба нийт аж үйлдвэрийн гарц хоёр сар дараалан буурчээ.

Европ: Худалдааны маргааны асуудалд ахиц гарч, Европын бүсийн STOXX Europe 600 индекс өсөлттэй хаагдлаа.

Их Британийн Парламент BREXIT-ийн товиг хойшлуулахыг дэмжлээ. Парламентын гишүүд BREXIT-ийн товиг хамгийн ойрхондоо 6-р сарын 30 хүртэл хойшлуулах саналтай байгаа ажээ. Үүний дараа Их Британийн FTSE 100 индекс өсөж, фүнт болоод еврогийн ханш ам.долларын эсрэг чангарсан байна.

Мөн BREXIT-ийн тодорхойгүй байдалтай холбоотойгоор Английн Төв банк бизнесийн хөрөнгө оруулалтыг энэ онд хоёр хувиар өснө гэсэн таамгаасаа буцаж, харин 2.75 хувиар буурна гэсэн урьдчилсан тооцоог шинэчилж хийсэн байна. Мөн Их Британийн Төсвийн хороо 2019 оны эдийн засгийн өсөлтийн таамгаа бууруулж, 1.6-аас 1.2 хувь болгожээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2 орчим хувиар өсжээ.

Тус улсын Засгийн газрын мэдээлснээр 2018 оны 3-р улиралд (9-12 сар) Японы дотоодын нийт бүтээгдэхүүн 1.9%-аар өссөн ба энэ нь урьдчилан таамаглаж байсан 1.4%-аас өндөр байгаа юм. Гэсэн ч дэлхийн эдийн засаг удааширч байгаатай холбоотойгоор ирэх улирлуудад Японы эдийн засаг төдийлөн өсөлт үзүүлэхгүй хэмээн шинжээчид үзэж байна.

БНХАУ: БНХАУ одоо хэрэгжүүлж байгаа эдийн засгийг дэмжих бодлогоо цаашид үргэлжлүүлэх зорилготой байгаагаа мэдэгдлээ. Мөн мөнгөний бодлогыг хэт зөөлрүүлэх, төсвийн зарцуулалтыг огцом нэмэгдүүлэхээс зайлсхийнэ гэж тус улсын Ерөнхий сайд Ли Көциан мэдэгдлээ. Тэрбээр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын чуулганыг хааж хэлсэн үгэндээ "Эдийн засагт тулгарсан эрсдэлүүдийн эсрэг арга хэмжээ авах"-аа онцолсон байна. Ингэхдээ зах зээлийн тоглогчдыг дэмжих санаачилгыг орхигдуулахгүй гэдгээ цохон тэмдэглэжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,744.91	-1.40% ▼
Dow Jones	АНУ	25,848.87	1.57% ▲
S&P 500	АНУ	2,822.48	2.89% ▲
Nasdaq	АНУ	7,688.53	3.78% ▲
S&P/TSX	Канад	16,140.35	0.90% ▲
FTSE 100	Их Британи	7,228.28	1.74% ▲
S&P/ASX 200	Австрали	6,175.20	-0.46% ▼
Nikkei 225	Япон	21,450.85	2.02% ▲
Hang Seng	Хонг Конг	29,012.26	2.78% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.93
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.24
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.77
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.50
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.68
DBM' 2023	USD	7.250%	102.79
TDBM' 2020	USD	9.375%	104.26

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.481	-0.01 ▼
Libor 3M	2.625	0.03 ▲
Libor 6M	2.671	-0.01 ▼
Libor 1YR	2.840	-0.02 ▼
US 2YR Bond	2.442	-0.03 ▼
US 3YR Bond	2.397	-0.04 ▼
US 5YR Bond	2.402	-0.03 ▼
US 10YR Bond	2.594	-0.04 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.03.15	Өөрчлөлт
USD	2,631.60	-0.11% ▼
CNY	391.83	-0.23% ▼
EUR	2,981.21	0.06% ▲
RUB	40.24	0.73% ▲
KRW	2.32	-0.43% ▼
JPY	23.56	-0.04% ▼
CAD	1,979.69	0.97% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,303.96	0.44% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.34	0.00% ▲
Зэс	USD/lb.	293.15	1.31% ▲
Нүүрс	USD/MT	91.25	-2.41% ▼
WTI газрын тос	USD/bbl.	58.43	4.21% ▲
Brent газрын тос	USD/bbl.	67.24	2.28% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.79	-2.79% ▼

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. II	6.90%
Бодлогын хүү	2019. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. I	11.10%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. I	12.10%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. I	4.90%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. I	16.80%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. I	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар “Ард Кредит ББСБ” ХК нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгож 5.2 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга олон нийтэд санал болгосон дүнгээс 3 дахин давсан. Харин хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 53 компанийн 2,562.3 сая төгрөгийн 9,467,569 ширхэг хувьцаа арилжигдав.


“Эрчим баян өлгий” /BOE/ компанийн хувьцаа 21.95%-аар буюу хамгийн ихээр өсч 1,000.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Дөрвөн-Уул” /DRU/ компанийн хувьцаа 22.22%-аар буурч 1,050.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 20,600 ширхэг үнэт цаас 1,860.7 сая төгрөгөөр арилжаалагджээ.


3-р сарын 15-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,467.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,744.91 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.40%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	4,423.1
Зах зээлийн үнэлгээ	2,467,825.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,744.91	-1.40% ▼
MSE I индекс	9,665.58	-0.61% ▼
MSE II индекс	8,293.48	-1.34% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Хөвсгөл алтан дуулга	1,311,856	1,283,047,665
Ард кредит	5,294,235	475,335,481
Ард даатгал	291,846	202,399,216
АПУ	278,639	176,003,098
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	678,000	101,700,000

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Эрчим баян өлгий	1,000.00	21.95% ▲
Монгол нэхмэл	2,070.00	14.94% ▲
Адуун чулуун	1,950.00	14.71% ▲
Нэхээсгүй эдлэл	2,340.00	14.71% ▲
Ремикон	33.30	13.65% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дөрвөн Уул	1,050.00	-22.22% ▼
Хэрлэн хивс	73.50	-15.52% ▼
Булган гурил тэжээл	900.00	-12.20% ▼
Түмэн шувуут	174.90	-7.96% ▼
Атар-Өргөө	65,050.00	-7.07% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Тэнгэр капитал	3,600,000,000
Би Ди Сек	2,696,779,168
Бумбат-Алтай	2,467,431,031
Ард Секьюритиз	1,700,321,500
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,696,395,590

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	619.42	659,175
Таван толгой	7,210.00	379,716
МИК	12,800.00	265,079
Говь	316.53	246,929
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	600	60,741,000	100,090	102,380	156	15.140%
2	ZGEB-BD-27/03/20-A0225-18	20,000	1,800,000,000	90,000	90,000	156	18.000%

Ногдол ашиг зарласан хувьцаат компаниуд

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.15
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.05.01-ний дотор
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	N/A	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Махимпекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	N/A	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	N/A	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	N/A	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	N/A	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	N/A	74.4	N/A	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	N/A	2019.05.01-2019.05.31
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	N/A	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01
21	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
22	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	N/A
23	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
24	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02

Ээлжит хурал зарласан хувьцаат компаниуд

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	LEND	ЛэндМН ББСБ ХК	2019.02.22	2019.03.23	12:00
2	DLH	Эм Эн Ди ХК	2019.03.11	2019.03.28	15:00
3	EAZ	Эрдэнэт авто зам ХК	2019.03.14	2019.03.29	10:00
4	BTG	Баянтээг ХК	2019.03.04	2019.04.01	10:00
5	GTL	Гутал ХК	2019.03.10	2019.04.01	11:00

ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
6	АНН	Хоринхоёрдугаар бааз ХК	2019.03.11	2019.04.01	13:00
7	MNB	Мон Наб ХК	2019.03.14	2019.04.04	14:00
8	MIB	Монинжбар ХК	2019.02.05	2019.04.05	14:30
9	HRD	Хүрд ХК	2019.03.04	2019.04.05	16:00
10	VIK	Баян-Алдар ХК	2019.03.04	2019.04.08	10:00
11	HUZ	Хөвсгөл усан зам ХК	2019.02.28	2019.04.08	09:00
12	MIE	Материалимпекс ХК	2019.03.11	2019.04.09	10:30
13	HRL	Хэрлэн хивс ХК	2019.03.21	2019.04.09	10:00
14	AZH	Алтайн зам ХК	2019.03.19	2019.04.10	16:00
15	BHL	Бөөний худалдаа ХК	2019.03.14	2019.04.10	16:00
16	DBL	Даваанбулаг ХК	2019.03.23	2019.04.10	14:00
17	ALI	Стандарт ноос ХК	2019.03.18	2019.04.10	15:00
18	CND	АСБИ ХК	2019.03.22	2019.04.11	10:00
19	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	2019.03.21	2019.04.11	11:00
20	TEX	Техникимпорт ХК	2019.03.11	2019.04.11	15:00
21	UBH	Улаанбаатар хивс ХК	2019.03.18	2019.04.11	11:00
22	DES	Дорнод худалдаа ХК	2019.03.22	2019.04.12	14:00
23	TLP	Тулпар ХК	2019.03.11	2019.04.15	15:00
24	ERS	Монгол алт ХК	2019.03.27	2019.04.17	11:00
25	TEE	Тээвэр дархан ХК	2019.03.27	2019.04.17	14:00
26	BRC	Барилга корпораци ХК	2019.03.18	2019.04.18	10:00
27	GOV	Говь ХК	2019.03.18	2019.04.18	10:00
28	DAZ	Дорнод авто зам ХК	2019.03.25	2019.04.18	15:00
29	NEH	Дархан нэхий ХК	2019.03.23	2019.04.21	12:00
30	ADL	Адуун чулуун ХК	2019.04.03	2019.04.22	14:00
31	BDS	Би Ди Сек ХК	2019.03.22	2019.04.23	10:00
32	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	2019.04.01	2019.04.23	11:00
33	SHV	Шивээ овоо ХК	2019.03.14	2019.04.25	14:00
34	BHG	Бөхөг ХК	2019.03.25	2019.04.25	10:00
35	TCK	Талх чихэр ХК	2019.04.03	2019.04.25	14:00
36	SHV	Шивээ овоо ХК	2019.03.14	2019.04.25	14:00
37	ALD	Азык ХК	2019.04.01	2019.04.26	14:00
38	ALA	Алтай нэгдэл ХК	2019.03.25	2019.04.26	11:00
39	EER	Ариг гал ХК	2019.04.02	2019.04.26	17:00
40	GHC	Ган хийц ХК	2019.03.22	2019.04.26	11:40
41	DZG	Дархан зочид буудал ХК	2019.03.28	2019.04.26	14:00
42	MMX	Махимпекс ХК	2019.04.03	2019.04.26	14:00
43	MNH	Монгол нэхмэл ХК	2019.03.25	2019.04.26	10:00
44	NRS	Шинэст ХК	2019.03.20	2019.04.26	10:00
45	AIC	Ард даатгал ХК	2019.03.15	2019.04.27	09:00
46	HSG	Хөсөг трейд ХК	2019.04.01	2019.04.27	12:00
47	JGL	Говийн өндөр ХК	2019.03.28	2019.04.29	09:00
48	MBW	Монгол базальт ХК	2019.03.25	2019.04.29	15:00
49		Таван толгой ХК	2019.04.01	2019.04.29	14:00
50	BSKY	Блюскай секьюритиз ХК	2019.03.20	2019.04.30	18:00
51	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК	2019.04.05	2019.04.30	14:00
52	TAL	Талын гал ХК	2019.03.26	2019.04.30	14:00
53	HGN	Хөх ган ХК	2019.03.28	2019.04.30	14:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

СЗХ: Дотоод мэдээллийн журмыг шинэчилж, шинээр гаргах хувьцааг бүртгэлээ

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 3-р сарын 13-ны өдөр хуралдаж, 20 орчим асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар, “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ыг шинэчлэн баталлаа. Журмаар, үнэт цаасны дотоод мэдээлэлд юу юуг тооцох, түүнийг нийтэд мэдээлэхэд баримтлах зарчим, дотоод мэдээлэл эзэмшигч гэж хэн болох, тэдэнд хориглох үйл ажиллагаа, журам зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэг бүрчлэн тогтоож өгсөн байна. Хөрөнгийн зах зээл хурдацтай хөгжиж буй энэ үед үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг урвуулан ашиглах, хуурамч арилжаа хийж, үнэ ханш, арилжааны хэмжээг зохиомлоор өсгөх, бууруулах, зах зээлд оролцогч харилцагчид, хөрөнгө оруулагчдыг мэхлэх зэрэг эрсдэл үүсэхээс энэхүү журмаар урьдчилан сэргийлэх юм.

Мөн хуралдаанаар, “Монос хүнс” ХХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, түүний 30 хувь буюу 122,655,128 ширхэгийг нэг бүрийг нь 70 төгрөгийн тогтоосон үнээр нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө. “Монос хүнс” ХХК олон нийтэд санал болгон худалдах нийт хувьцааны 50 хувь буюу 61.3 сая ширхгийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 50 хувь буюу 61.3 сая ширхгийг нийтэд санал болгон худалдаж, нийт 8.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг “Голомт Капитал ҮЦК” ХХК, аудитын үйлчилгээг “Грант торнтон” ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг “Өмгөөллийн И Эл Си” ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг “Итгэлт-Эстимэйт” ХХК тус тус үзүүлж байна.

Түүнчлэн “Райнос эссет менежмент монгол” ХХК, “Ти Би ассет менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



“Баян-Алдар” ХК-ийн үнэт цаасны арилжааг нээхээр боллоо

“Баян-Алдар” ХК-д “Монгорүматрикс Гинко” ХХК-г нэгтгэх үйл явцтай холбогдох өөрчлөлтийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 20 тоот албан шаардлагын дагуу “Баян-Алдар” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн нээхээр боллоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МХБ-д бүртгэлтэй ХК-иудын 90 хувь нь 2018 оны санхүүгийн тайлангаа олон нийтэд ил болгоод байна

Гуравдугаар сарын 15-ны байдлаар Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 198 компаниас 177 компани 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлээд байна.

Өөрөөр хэлбэл, нийт бүртгэлтэй компаниудын 90 орчим хувь нь санхүүгийн тайлангаа олон нийтэд ил болгоод байгаа юм. Харин өнгөрсөн оны мөн үед Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 225 компанийн 111 нь буюу ердөө 50 хүрэхгүй хувь нь санхүүгийн тайлангаа ирүүлж байжээ. Үүнээс харахад хууль, дүрэм журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй компаниудыг бүртгэлээс хасаж, компаниудын чанарт анхаарч эхэлснээр хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилт сайжирсан байгаа юм.

2018 оны санхүүгийн тайлангаа ирүүлсэн компаниудаас 83 нь ашигтай, 72 нь алдагдалтай ажилласан бол 22 компани үйл ажиллагаа явуулаагүй байна. Эдгээрээс АПУ, “МИК Холдинг”, “Тавантолгой” компаниуд тус бүр 50-иас дээш тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, ашгийн хэмжээгээр тэргүүлжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ-д бүртгэлтэй ХК-иудын 25 хувь нь ХЭХ-ын товоо зарлаад байна

Баасан гарагийн байдлаар Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 198 компаниас 53 нь хувьцаа эзэмшигчдийн хурлын товоо зарлаж, гурван компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээд байна.

“Гермес центр”, “Их барилга”, “Эрдэнэт суварга” компаниуд хурлаа хийгээд байгаа бөгөөд “Гермес центр” компани хурлын шийдвэрээ олон нийтэд танилцуулаад байгаа юм. Хувьцаат компаниуд гуравдугаар сарын 21-ний дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын товоо гаргах үүрэгтэй. Мөн компанийн тухай хуульд заасны дагуу дөрөвдүгээр сарын 30-ны дотор хурлаа хийх шаардлагатай байдаг ажээ.

2018 онд 130 гаруй компани хуулийн хугацаандаа хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж байсан талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарласан компаниудаас “ЛэндМН ББСБ” компани хурлаа гуравдугаар сарын 23-нд хийхээр товлоод байна. Тус компани гүйцэтгэх удирдлага болон ажиллагсдад дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор ТУЗ-өөс тогтоосон хэмжээ, нөхцөлөөр компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах эсэхээ энэ хурлаар шийдвэрлэх юм байна.

Мөн жилийн өмнө IPO гаргаж байсан “Монгол базальт” компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах эсэхээ 4-р сарын 29-нд болох хурлаараа шийдвэрлэх юм. Харин одоогоор хурлын товоо гаргаагүй байгаа ч “АПУ” болон “Сүү” компани дөрөвдүгээр сарын эцсээр хурлаа хийхээр төлөвлөж байгаагаа мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Эрдсийн экспорт 20%-аар өсөв

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны хоёрдугаар сарын байдлаар 1.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 23.4%-аар өссөн байна. Үүнээс, нийт экспорт 1.1 тэрбум ам.доллар /30.4%-ийн өсөлттэй/, импорт 837.5 сая ам.доллартай /15.4%-ийн өсөлттэй/ тэнцжээ. Гадаад худалдааны нийт тэнцэл өнгөрсөн сард 256.1 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 143.7 сая доллараар өссөн дүн юм.

Гэхдээ өнгөрсөн хоёрдугаар сарын хувьд экспорт, импорт хоёул өмнөх нэгдүгээр сарынхтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарчээ.

2-р сарын байдлаар эрдсийн экспорт 826.2 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 19.6%-аар өсжээ. Орлогоор тэргүүлэгч салбар болох нүүрсний экспорт 334.2 сая ам.долларт хүрч 36.2%-аар нэмэгдсэн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ эхний хоёр сард 4.07 сая тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25.5%-аар давлаа. Гэхдээ сарын дүнгээр авч үзвэл өнгөрсөн хоёрдугаар сард нүүрсний экспортын биет хэмжээ 1.91 сая тоннтай тэнцсэн нь өмнөх нэгдүгээр сарынхаас 251 мянган тонн буюу 12 орчим хувиар буурсан дүнтэй гарлаа.

Зэсийн баяжмалын экспортын тухайд мөн хугацаанд 229.4 мянган тонн бүтээгдэхүүн нийлүүлж 309 сая ам.долларын орлого олсон нь биет хэмжээгээр 11.8%-аар, үнийн дүнгээр 12.5%-аар тус тус нэмэгдсэн байна. Боловсруулсан цэвэр зэсийн хувьд мөн хугацаанд 1,521 тонн бүтээгдэхүүн экспортолж, 8.9 орчим сая ам.долларын орлого олсон нь жингээр 34.5%-аар, орлогын хувьд 43.8%-аар тус тус буурчээ.

Түүхий газрын тосны тухайд манай улс өнгөрсөн сарын байдлаар нийтдээ 1 сая баррелийн экспорт хийсэн бөгөөд 53 орчим сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь биет хэмжээгээр өнгөрсөн оны түвшинд хэвээр, харин үнийн дүнгээр 15.4%-аар буурчээ.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт өнгөрсөн сард 4.7 тоннд хүрч, орлогын дүнгээр 196 орчим сая ам.доллартай тэнцсэн нь өмнөх оны мөн үеийнхээс жингээр 2.8 дахин, орлогоор 2.7 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Гэхдээ Монголбанкны мэдээлж буйгаар алт худалдан авалт оны эхний хоёр сарын байдлаар 84.1 кг-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81%-аар буурсан үзүүлэлт болохыг мэдээлсэн билээ.

Төмрийн хүдрийн экспортын хувьд өнгөрсөн сард нийтдээ 1.2 орчим сая тонн бүтээгдэхүүн гадагш нийлүүлж, 52.2 сая ам.доллар олсон нь биет хэмжээгээр 26.7%, орлогын дүнгээр 31.8%-аар тус тус өссөнийг илтгэв.

Цайрын хүдэр, баяжмалын экспорт өнгөрсөн сард 24.6 мянган тоннд хүрч, 34.4 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь жингээр 16.5%-аар өссөн боловч орлогын дүнгээр 7.3%-аар буурсан байна.

Жоншны хүдэр, баяжмалын экспорт оны эхний хоёр сарын байдлаар 69.2 мянган тоннд хүрсэн нь өмнөх оныхоосоо 39.9%-аар нэмэгдсэн бол орлогын хувьд 23.3 сая ам.доллар олж 49.1%-ийн өсөлтийг харуулав.

Хар тугалганы хүдэр, баяжмалын экспорт хоёрдугаар сарын байдлаар 3 мянган тоннд хүрч 7 сая ам.долларын орлого олсон нь жингээр 22.5%, үнийн дүнгээр 5.8%-аар тус тус өсөв.

Молибденийн баяжмалын экспорт биет хэмжээгээр 0.9 мянган тонн, орлогын дүн 8.2 сая ам.доллартай тэнцжээ. Энэ нь жингээр ялимгүй бууралттай, үнийн дүнгээр 34.8%-аар нэмэгдсэн байна.

Гянтболдын хүдэр, баяжмалын экспорт өнгөрсөн сард 45 тоннд хүрч, 495.3 мянган ам.долларын орлого олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад жингээр 11.6%-аар, үнийн дүнгээр 19.2%-аар тус тус буурчээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

“Оюутолгой”-н орлого өнгөрсөн онд 25.6%-иар өсөв

“Оюутолгой” компани өнгөрсөн оны санхүүгийн тайлангаа танилцууллаа. 2018 онд тус компанийн борлуулалтын орлого 1.18 тэрбум ам.долларт хүрчээ. 2017 онд компанийн борлуулалт 939.8 сая ам.доллартай тэнцэж байсан юм.

Ийнхүү борлуулалт өсөхөд баяжмал дахь алтны агууламж огцом нэмэгдсэн төдийгүй зэсийн борлуулалтын хэмжээ дээшилсэн. Мөн өнгөрсөн оны хэмжээнд зэсийн зах зээлийн дундаж үнэ өндөр байсан нь орлогын үзүүлэлт 25.6%-аар өсөхөд голлон нөлөөлжээ.

Тодруулбал өнгөрсөн онд алтны борлуулалтын үзүүлэлт 300.4 сая ам.долларт хүрсэн нь 2017 оны үзүүлэлттэй харьцуулахад 129.7%-аар нэмэгдсэн байна.

Тус компанийн хувьд өнгөрсөн онд төлсөн нийт роялтийн хэмжээ 70.8 сая ам.долларт хүрсэн нь 2017 оныхоос 24%-аар өсжээ.

Мөн үйлдвэрлэсэн зэсийн бүтээгдэхүүнд ногдох нийт (AISC) зардал өнгөрсөн оны хэмжээнд фунт тутамд 2.2 ам.доллар (тоннд шилжүүлсэн дүнгээр ~4850 ам.доллар) байсан нь 2017 оны үзүүлэлт болох 2.39 ам.доллараас доогуур үзүүлэлт юм.

Оюутолгой ил уурхайн тоног төхөөрөмжийн зардал (CAPEX) өнгөрсөн онд 90.5 сая доллар байсан бол далд уурхайн бүтээн байгуулалтад 1.219 орчим тэрбум ам.доллар зарцуулжээ. Далд уурхайн хөрөнгө оруулалтын зардал энэ онд 1.3-1.4 тэрбум ам.доллар, ил уурхайд 150-180 сая ам.доллар байхаар төлөвлөснийг компанийн зүгээс мэдээллээ.

Оюутолгой ил уурхайгаас энэ онд 125-155 мянган тонн зэс, 180-220 мянган унц алт үйлдвэрлэх төлөвтэй. Энэ онд үйл ажиллагаа, олборлолтын зардал 800-850 сая ам.долларт хэлбэлзэхээр байгаа бол өнгөрсөн онд уг үзүүлэлт 817.1 сая ам.доллар байжээ.

Далд уурхайн хөндлөн нэвтрэлт өнгөрсөн онд 10.3 км-т хүрч, харин энэ жил 15-16 км-т хүргэхээр төлөвлөжээ. Гэхдээ энэ оны малталтын ажлын төлөвлөгөөг “Рио Тинто” компаниас сүүлд өгсөн зөвлөмжийн дагуу дахиж хянаж байгаа ажээ. “Туркойз Хилл” компани далд уурхайг ашиглалтад оруулах хугацаа 2021 оны гуравдугаар улирлаас хойшилж магадгүйг урьд нь мэдэгдсэн бөгөөд үүнээс гарах үр дүнгийн судалгааг “Рио Тинто” групптэй хамтран хийж буйгаа илэрхийлжээ.

Мөн өнгөрсөн оны төгсгөлд үзэглэсэн Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээний дараа Тавантолгойн цахилгаан станцын холбогдох судалгааны ажлыг урагшлуулж байгаа талаар “Туркойз Хилл” мэдээлэлдээ тэмдэглэжээ. Холбогдох судалгааг хийж дууссаны дараа цахилгаан станцын төсөлд шаардлагатай санхүүжилт тодорхой болох бөгөөд энэ үеэр далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн нийт хэмжээг эцэслэн тогтоох юм байна.

2015 оны төгсгөлд Оюутолгойн өргөтгөлийн төсөлд нийт 4.4 тэрбум ам.долларын зээлийн санхүүжилтийн гэрээг тус компани олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай үзэглэсэн бөгөөд зээлийн боломжит хэмжээг 6 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлж болохоор тогтсон билээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БСАД МЭДЭЭ

ҮСХ: Монгол улсын эдийн засгийн 2-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2019 оны 2 дугаар сарын эцэст 19.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.7 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3.7 (23.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 2 дугаар сарын эцэст 854.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 185.1 (17.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3.7 (0.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 2 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 28.0 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.4 (24.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 2 дугаар сарын эцэст 926.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 92.2 (11.0%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 66.2 (6.7%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.4 хувийг эзэлж, өмнөх сараас 0.6 пунктээр өсөж, өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 2 дугаар сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 56.4 (3.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 578.2 (45.7%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна.

Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 2 дугаар сард 2 633.37 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар суларч, өмнөх сараас 0.6 хувиар чангарсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 2 дугаар сард 390.81 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар тус тус суларчээ.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1454.3 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1152.3 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 302.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 2 дугаар сард 763.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 73.2 (10.6%) тэрбум төгрөгөөр, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 594.0 тэрбум төгрөгт хүрч, 35.8 (6.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Татварын нийт орлого 2019 оны эхний 2 сард 1331.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 272.8 (25.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 75.4 (23.9%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 56.2 (25.9%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 44.8 (20.6%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 42.2 (39.1%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 35.5 (33.3%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 16.9 (20.9%) тэрбум төгрөг төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.3 хувийг татварын орлого, 7.5 хувийг татварын бус орлого, 10.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.5 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 125.3 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.8 сая америк доллараар өсжээ.

Урсгал данс 133.3 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 214.4 сая америк доллар, анхдагч орлогын данс 52.0 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны 1 дүгээр сард 8.0 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.8 (54.3%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 136.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 272.2 сая америк доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2019 оны 1 дүгээр сард 128.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 361.2 сая америк доллараар өссөн байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны эцсээс 1.1 хувь, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 22.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 4.5 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10.9 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 13.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 2 дугаар сард өмнөх оны эцсээс 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 9.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлэг болон хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ тус бүр 1.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.